



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 04 өдөр

Дугаар 1/247

Сүхбаатар сум

Бод малд үзлэг ангилалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а", Малын генетик нөөцийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3. 18.13.1 дэх заалт, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны сайдын 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/68 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бод малд үзлэг ангилалт хийх, ашиг шимийн гарц тодорхойлох, цөм сүрэг бүрдүүлэх, хээлтүүлэгч малыг ялган тэмдэглэх, ээмэгжүүлэх ажлыг 2020 оны 10 дугаар сард багтаан зохион байгуулсугай.

2.Үзлэг ангилалтад хамрагдах малын тоо, ажиллах мэргэжилтний хуваарийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

3.Ангилалт хийх ажлын хэсгийг сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасгийн мал зүйч, мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжийн захирал, малчдын төлөөллийг оролцуулан, өөрсдийн дотоод нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Бод малд үзлэг ангилалт хийсэн ажлын тайланг 2020 оны 11 дүгээр сарын 01-ний дотор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт, сумдад ажиллах ажлын хэсгийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, ажлын тайланг 2020 оны 11 дүгээр сарын 15-ны дотор аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Б.Мөнхтөр/-д, мал сүрэгт үзлэг, ангилалт хийж, үүлдэрлэг байдлыг тодорхойлох ажилд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Баттүвшин/ нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

Аймгийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн 127 дугаар захирамжийн хавсралт

ҮЗЛЭГ АНГИЛАЛТ ХИЙХ БОД МАЛЫН ТОО, ХУВААРЬ

Д/д	Сумын нэр	Үхэр	Бүгд	Үзлэг ангилалт хийх малын тоо		Ажиллах мэргэжилтэн
				Үхэр	Бүгд	
1	Сүхбаатар	2335	2335	234	234	Сумын хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн Н.Хишиг, Шинжээч малзүйч Э.Мягмарсүрэн
2	Алтанбулаг	4085	4085	409	409	ХХААГ-ын МУА-ны мэргэжилтэн М.Баасанжаргал, Сумын ХАА-н тасгийн мал зүйч Г.Мөнхболд
3	Баруунбүрэн	6175	6175	618	618	ХХААГ-ын МУА-ны мэргэжилтэн М.Баасанжаргал, Сумын ХАА-н тасгийн мал зүйч С.Ганхуяг
4	Баянгол	7759	7759	776	776	Шинжээч мал зүйч Э.Мягмарсүрэн ХАА-н тасгийн мал зүйч Н.Давааням
5	Ерөө	5946	5946	595	595	Ахмад мал зүйч Ц.Алтанцэцэг ХАА-н тасгийн мал зүйч Э.Нандинцэцэг
6	Жавхланта	4553	4553	455	455	Шинжээч мал зүйч Э.Мягмарсүрэн ХАА-н тасгийн мал зүйч Х.Дуламсүрэн
7	Зүүнбүрэн	5663	5663	566	566	Шинжээч мал зүйч Э.Мягмарсүрэн Сумын ХАА-н тасгийн мал зүйч Б.Монхтөр
8	Мандал	14747	14747	1475	1475	ХХААГ-ын МУА-ны мэргэжилтэн М.Баасанжаргал, ХАА-н тасгийн мал зүйч Б.Батзориг
9	Орхон	4791	4791	479	479	Ахмад мал зүйч Ц.Алтанцэцэг ХАА-н тасгийн мал зүйч Ж.Түшигбаяр
10	Орхонтуул	7315	7315	732	732	ХХААГ-ын МУА-ны мэргэжилтэн М.Баасанжаргал Сумын ХАА-н тасгийн мал зүйч Н.Өсөхбаяр
11	Сайхан	5324	5324	532	532	Ахмад мал зүйч Ц.Алтанцэцэг, сумын ХАА-н тасгийн мал зүйч Б.Эрдэнэбулган
12	Сант	4695	4695	470	470	ХХААГ-ын МУА-ны дарга Х.Цэнгэлсайхан, сумын ХАА-н тасгийн мал зүйч Ц.Бямбацэцэг
13	Түшиг	3104	3104	310	310	ХХААГ-ын МУА-ны мэргэжилтэн М.Баасанжаргал, ХАА-н тасгийн мал зүйч Х.Гүнжидмаа
14	Хүдэр	3647	3647	365	365	ХХААГ-ын МУА-ны мэргэжилтэн М.Баасанжаргал, ХАА-н тасгийн мал зүйч Г.Мөнхбаатар
15	Хушаат	5793	5793	579	579	ХХААГ-ын МУА-ны мэргэжилтэн М.Баасанжаргал, Хушаатын хамтын хүч хоршоо
16	Цагааннуур	9971	9971	997	997	ХХААГ-ын МУА-ны мэргэжилтэн М.Баасанжаргал, Сумын ХАА-н тасгийн мал зүйч Ч.Лтагхуяг
17	Шаамар	3103	3103	310	310	Сумын ХАА-н тасгийн мал зүйч Ц.Ганзориг, Шинжээч мал зүйч Э.Мягмарсүрэн
	Бүгд	99006	99006	9902	9902	